



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар A/79

Жаргалтхаан

Газар эзэмших эрхийг өвлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэн Юндэндоржийн Чанцалдарий (СМ51090100) нь нас барсан тул 2-р баг, Эрхийн ус хаягт орших, 2319002511 нэгж талбарын дугаартай, хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын, 2-р баг, Зусаал хаягт орших, 2319002222 нэгж талбарын дугаартай, өвөлжөөний зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг түүний өвлөгч Пельчирийн Алтанзаяа (СМ82062600)-д тус тус өвлүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмших эрх өвлөгчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны Б/31, 2017 оны А/76 дугаар захирамжуудын хавсралтын холбогдох хэсгүүд, Ю.Чанцалдарийгийн эзэмшлийн 0000021489, 0000021490 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээгүүдийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401183